



ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2026.03.16 № 03/1829
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

“Агронэгтгэл трейд” ХХК танай байгууллагатай 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан ЭХЭМҮТ/20250102005/02/01/01 дугаартай гэрээний үүргээ зөрчиж, гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүнийг нийлүүлэхгүй байгаа асуудалд арга зүйн зөвлөмж хүссэн тухай танай албан бичигтэй танилцлаа.

Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулсан худалдан авах гэрээтэй холбоотой асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид “худалдан авах гэрээ” гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна.” гэж, мөн зүйлийн 39.5 дахь хэсэгт “Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна.” гэж тус тус заасныг анхаарна уу.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.БАЯРМАГНАЙ

9766003124